

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 дугаар тушаалын  
6 дугаар хавсралт

**Хөдөлмөр бодлогын газрын Нийгмийн халамжийн хэлтсийн дарга  
Юрагийн Отгонбилэгийн 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/ Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэ лтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	5		
1	2	3	4	6	7			
<b>Зорилт 1. “2.1.1. Хөдөлмөр эрхлээгүй иргэдийг ажлын байраар хангах, ядуурлыг бууруулах, тогтвортой ажлын байр бий болгохыг дэмжих арга хэмжээний хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэх”</b>								
1.	<b>Арга хэмжээ 1.1.</b> Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлнэ.	100%	30%	70%	“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилж, ядуурлыг бууруулах бодлого баримтална.” гэж заасан. Энэхүү бодлогын зорилттой уялдуулан Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024.11.27-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/58 дугаар тушаалаар байгуулан, Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул ахлан, судалгааны дэд ажлын хэсэгт судлаач, багш, төрийн болон төрийн бус	01-06		

					<p>байгууллагын төлөөллийг оролцуулан ажиллаж байна.</p> <p>Нийгмийн халамжийн тухай хуулийн үзэл баримтлалыг 2024.12.20-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталсан.</p> <p>Хуулийн төслийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Орхон аймгийн ХХҮГ, Чингэлтэй дүүргийн ХХҮХ-ийн холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан саналыг тусган, хамтран боловсруулсан.</p> <p>Хуулийн төслийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлж, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, сум, хорооны бүх албан хаагчдад танилцуулж хэлэлцүүлэн, саналыг нэгтгэн 2025.05.29-ний өдрийн 01/911 дүгээр албан бичгээр ирүүлсэн.</p> <p>Хуулийн төслийг УИХ-ын дарга, УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд, тус байнгын хорооны албан хаагчдад танилцуулах уулзалтыг 3 удаа зохион байгуулсан. Хуулийн төслийн хэлэлцүүлгийг төрийн болон төрийн бус байгууллагыг оролцуулан танхимаар болон цахимаар нийт 10 гаруй удаа зохион байгуулсан.</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>Мөн хуулийн төсөлд иргэд олон нийтээс санал авахаар 2025.04.16-ны өдөр яамны цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Хэлэлцүүлгийн саналыг тусган хуулийн төслийг эцэслэн боловсруулж, товч танилцуулга, тандан судалгаа, зардлын тооцоо, үр нөлөөний үнэлгээний хамт 2025.05.06-ны өдрийн “Санал авах тухай” 01/1454 дүгээр албан бичгээр Засгийн газрын гишүүдэд санал авахаар хүргүүлсэн.</p> <p>Яамдын Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгөхөөр ажиллаж байгаа мэргэжилтнүүдэд 2025.05.23-ны өдөр хуулийн төслийн үндсэн агуулгыг танилцуулан, мэдээлэл өгөх, санал солилцох хэлэлцүүлгийг зохион байгууллаа.</p> <p>Яамдаас ирүүлсэн саналыг тусган хуулийн төслийг сайжруулан боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу 2025.06.06-ны өдрийн 01/1884 дугаар албан бичгээр Сангийн яамнаас, мөн өдрийн 01/1881 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар хүргүүлсэн.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2025.06.12-ны өдрийн 1/3209 дүгээр албан бичгээр Засгийн газрын</p>	
--	--	--	--	--	---	--

					хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл ирүүлсэн.  Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийн иж бүрдлийг ханган Засгийн газар болон Улсын Их хуралд өргөн мэдүүлэхээр бэлэн болсон.		
	<b>Дэд арга хэмжээ – 1.1.1:</b> Хуулийн төслийг шинэчлэн боловсруулна.	100%	30%	70%	<p>Нийгмийн халамжийн тухай хуулийн үзэл баримтлалыг 2024.12.20-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамtran баталсан.</p> <p>Хуулийн төслийг батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн, хэлэлцүүлгээс гарсан санал болон яамдаас ирүүлсэн саналыг тусган хуулийн төслийг эцэслэн боловсрууллаа.</p> <p>Хуулийн төслийг боловсруулахдаа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Орхон аймгийн ХХҮГ, Чингэлтэй дүүргийн ХХҮХ-ийн холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан саналыг тусган, хамtran боловсруулсан.</p> <p>Хуулийн төслийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлж, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн бүх албан хаагчдад танилцуулж хэлэлцүүлэн, саналыг нэлгэн 2025.05.29-ний өдрийн 01/911 дүгээр албан бичгээр ирүүлсэн.</p> <p>Ирүүлсэн саналыг тусган Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий</p>	01-06	

				<p>газар, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс холбогдох байгууллагуудад танилцуулах арга хэмжээг зохион байгуулж, Засгийн газрын гишүүдээс ирүүлсэн саналыг тусган эцэслэн боловсруулсан.</p> <p>Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийн иж бурдлийг ханганд Засгийн газрын хуралдаанд өргөн мэдүүлэхээр бэлэн болсон.</p>		
<b>Дэд арга хэмжээ – 1.1.2:</b> Зардлын тооцоо, үр нэлөөний үнэлгээ болон бусад холбогдох баримт бичгийг боловсруулна.	100%	30%	70%	<p>Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулан зардлын тооцоо, үр нэлөөний үнэлгээг статистик тоо баримт, бодлогын зөвлөмж, судалгааны тайлангуудад үндэслэн боловсрууллаа. Мөн хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийг Засгийн газар, Улсын Их Хуралд өргөн мэдүүлхэдэ шаардлагатай дараах баримт бичгийг боловсруулсан:</p> <ol style="list-style-type: none"> <li>Хуулийн төслийн үзэл баримтлал;</li> <li>Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын;</li> <li>Дагалдах 18 хуулийн төсөл;</li> <li>Хуулийн төслийн товч танилцуулга</li> <li>Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга;</li> </ol>	01-06	

				<p>6. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа;</p> <p>7. Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ;</p> <p>8. Хуулийн төсөл хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо;</p> <p>9. Хэлэлцүүлгийн тайлан /Олон нийт, холбогдох бусад байгууллага, иргэд/;</p> <p>10. Бодлогын зөвлөмжийн нэгтгэл болон хуулийн төслийн хэлэлцүүлэгт шаардлагатай бусад материал.</p> <p>Баримт бичгийг Хууль тогтоомжийн тухай хууль болон бусад баримт бичигт заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж бэлтгэлээ.</p>		
<b>Дэд арга хэмжээ – 1.1.3:</b> Хуулийн төслийг оролцогч талуудад хэлэлцүүлэн санал авч тусгана.	100%	30%	70%	<p>Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж, дараах байдлаар хэлэлцүүллээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ 2025.01.16-ны өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024.11.27-ны өдрийн А/58 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүдэд танилцуулан хэлэлцүүлэв.</li> <li>✓ 2025.01.22-ны өдөр Нийгмийн халамжийн тухай хуулийг боловсруулах судалгааны дэд ажлын хэсгийн гишүүдэд танилцуулан хэлэлцүүлэв.</li> <li>✓ 2025.01.29-ний өдөр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус</li> </ul>	01-06	

байгууллагууд, тэдгээрийн төлөөлөл /цахимаар 96, танхимаар 16/-д танилцуулан хэлэлцүүлэв.

✓ 2025.01.29-ний өдөр аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хэлтсийн Нийгмийн халамжийн хэлтэс, албадын дарга нар /30 хүн/-т цахимаар танилцуулан хэлэлцүүлэв.

✓ 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр Нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагудын төлөөлөл /25 хүн/-д танилцуулан хэлэлцүүлэв.

✓ 2025.02.05-07-ны өдрүүдэд ХХҮЕГ, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын мэргэжилтнүүдтэй хамтран Нийгмийн халамжийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах саналыг хэлэлцүүлэв.

✓ 2025.05.09-ний өдөр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон ТББ-үүд /ЭМЯ, НДЕГ, ХБХХЕГ, ХХҮЕГ, ТББ-үүд/-д танилцуулан санал авч, хэлэлцүүллээ.

✓ 2025.05.23-ны өдөр яамдын Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгөхөөр ажиллаж байгаа мэргэжилтнүүдэд мэдээлэл өгөх, санал солилцох хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

					<p>✓ 2025.06.03-ны өдөр Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, төрийн бус байгууллага, холбоодод Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулан танилцуулан санал авч, хэлэлцүүллээ.</p> <p>Хуулийн төслийг УИХ-ын дарга, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Төрийн нарийн бичгийн дарга, УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд, тус байнгын хорооны албан хаагчдад танилцуулах уулзалтыг нийт 10 гаруй удаа зохион байгуулсан. Мөн яамны холбогдох газар хэлтсийн дарга болон, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс холбогдох байгууллагуудад танилцуулах арга хэмжээг мөн нийт 10 гаруй удаа зохион байгуулсан.</p> <p>Олон нийтээс санал авах зорилгоор тус яамны цахим хуудсанд 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төслийг байршуулсан.</p> <p>Түүнчлэн цахимаар, утсаар, биечлэн ирүүлсэн саналуудыг судлан үзэж хуулийн төсөлд тусгалаа.</p>	
2.	<b>Арга хэмжээ 1.2.</b>	100%	0	100%	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлд ахмад	

			<p>настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох протез, ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийг нийгмийн халамжийн сангаас олгох журам, хэмжээг тус тус заасан. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 363 дугаар тогтоолоор “Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ”-ийг баталж, нийгмийн халамжийн сангаас үнийн хөнгөлөлтийг олгож байна.</p> <p>2024 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалах ТББ-үуд, эцэг, эхийн зүгээс “Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт”-д байнгын асаргаа шаардлагатай, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн живхийг оруулахаар тус яаманд санал ирүүлсний дагуу уг зардлыг 2025 төсөвт тусгаж, Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, 2025.04.11-ний өдрийн 01/1161 албан бичгээр яамдаас саналыг авч, тусгасан.</p> <p>Ингэснээр Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнийг шинэчлэн батлах тухай” 363 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийгмийн халамжийн сангаас олгох протез,</p>	01-06
--	--	--	--	-------

			<p>ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ"-д нэмэлт оруулж 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын 248 дугаар тогтоолыг батлуулсан.</p> <p>Батлагдсан төсөвтэй уялдуулан байнгын асаргаа шаардлагатай, хүнд хэлбэрийн өдөр тутам живх хэрэглэдэг, 2-оос дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох живхний үнийг 3 жилд нэг удаа олгох 1,800,000 төгрөг олгохоор Засгийн газрын тогтоолоор батлуулав.</p> <p>Түүнчлэн иргэдээс сонсголын аппаратны чанар, эдэлгээ, нийлүүлэлтийн асуудлаар өргөдөл, гомдол нэлээд олон ирдэг. Үүнтэй холбогдуулан хяналт, шалгалт, аудитын байгууллагаас олон зэрчил илрүүлж, дүгнэлт, зөвлөмж өгдөг. Иргэдийн хэрэгцээг хангадаггүй, чанар, эдэлгээ муутай, шуугидаг, зай нь амархан мууддаг, хямд үнэтэй сонсголын аппарат нийлүүлдэг, таарч тохирохгүй сонсголын аппарат хэрэглэснээр гарч болзошгүй хүндрэл, бэрхшээл үүсдэг талаар иргэдээс гомдол ирдэг. Иймд Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын 248 дугаар тогтоолоор "сонсголын дижитал</p>	
--	--	--	--	--

					аппаратны чанарт тавигдах техникийн үзүүлэлт"-ийг нэмж тусган батлуулсан.		
3.	<b>Арга хэмжээ 1.3.</b>  Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулахад Эрүүл мэндийн яам, харьяа байгууллагатай хамtran ажиллах, чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулна.	100%	0	100%	<p>Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сай, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/28, А/27 тоот хамтарсан тушаалаар баталсан “Ахмад настанд цогц туслам, үйлчилгээ үзүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах журам”-д заасан Мэргэжлийн хамтарсан багийн шийдвэрийг хэрэгжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааг хангах Орон тооны бус ажлын хэсгийг журамд заасан албан тушаалтнуудыг оролцуулсан уулзалтыг 2025.05.07-ны өдөр ГБХНХЯ-д зохион байгуулж, холбогдох эрх зүйн орчин, хэрэгжүүлэх чиг үүрэг, Мэргэжлийн хамтарсан багийн хурлыг товлох, бэлтгэх арга хэмжээг хэлэлцэв.</p> <p>Үүний дагуу Мэргэжлийн хамтарсан багийн 2025 оны анхны хурлыг 2025.06.02-ны өдөр ГБХНХЯ-д зохион байгуулж, Мэргэжлийн хамтарсан багийн үйл ажиллагаанд Эрүүл мэндийн яам, ГБХНХ, тэдгээрийн харьяа байгууллага, Нийгмийн ажлын мэргэжлийн холбоо, Ахмадын холбооны оролцоо, хийх ажлыг тодорхойлж, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга наарт хүргэх албан бичгийн төслийг хэлэлцэв. Үүний дагуу ЭМЯ, ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга нар хамtran 2025 оны</p>	01-06	

					төлөвлөгөөг батлан бүх Засаг дарга нарт албан бичгээр хүргүүлэх төслийг бэлтгэв.		
4.	<p><b>Арга хэмжээ 1.4.</b>  <b>"Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, батлуулна.</b></p>	100%	0	100%	<p>Засгийн газрын 2021 оны 362 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам"-ыг хэрэгжүүлэх явцад гарсан тодорхой тусгах шаардлагатай зарим асуудал, үйлчилгээг хүргэх процессыг хялбарчлах хэрэгцээ шаардлагад үндэслэн "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулав.</p> <p>Журмын төслийг боловсруулан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлэн, аймаг дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс санал авч саналыг тусган эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.</p> <p>Журмын төсөлд нэг гэр бүлийн бүтэн өнчин хүүхдийг гэр бүлдээ авч асарч байгаа тохиолдолд хүүхдийн тоо хязгаарлахгүй байх, төрөлжсөн асрамжийн газарт асуулж байгаа тэжээгч нас барсан хүүхдийг халамжийн тэтгэвэрт хамруулах, тэтгэврийг банканд хадгалах, насанд хүрэх эсхүл асрамжаас гарахад тэтгэврийн мөнгийг хүлээлгэн өгөх, хяналт тавих зохицуулалтыг тусгах, тэтгэвэр,</p>	01-06	

					<p>тэтгэмжийн мөнгийг барьцаалж зээл авах, олгох, банкны зээлд суутгахыг хориглох, хяналт, шинжилгээ, үнэлгээ, хариуцлагын заалт болон иргэдийн санал гомдлыг нээлттэй хүлээн авч шийдвэрлэх зэрэг зохицуулалтыг нэмж тусгасан.</p> <p>Засгийн газрын 2024 оны 247 дугаар тоогоолын хүрээнд Байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох асаргааны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд үүнтэй холбогдуулан тэтгэмжид хамруулах хүүхдийн тооцоо судалгааг хийж ажилласан.</p> <p>Журмын нэмэлт өөрчлөлтийг 2025 оны сүүлийн хагас жилд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулна.</p>	
5.	<p><b>Арга хэмжээ 1.5.</b>            "Хүнсний эрхийн бичиг олгох журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тушаалын төслийг боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлуулна.</p>	Сайдын тушаал-1	0	100%	<p>"Хүнсний эрхийн бичиг олгох журам"-ын төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024.11.27-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/162 дугаар тушаалаар байгуулан журмын төслийг боловсруулан ажиллаж байна. Мөн журамд санал авахаар 2024.11.19-ний өдрийн "Санал авах тухай" 09/1292 дугаар албан бичгийг боловсруулан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлж, ирүүлсэн саналыг журмын төсөлд тусган ажиллагаа. Мөн журам</p>	02-06

					<p>шинэчлэх чиглэлээр ХХҮЕГазартай 2 удаа уулзалт хийж харьяа газруудаас санал авч ажиллаж байна.</p> <p>Мөн энэ ажлын хүрээнд Нийгмийн хадамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлага өрх иргэний Өрхийн мэдээллийн нэгдсэн санг шинэчлэх ажлыг ХХҮЕГ-т чиглэл өгөн хамtran хийж байна. Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны "Аргачлал шинэчлэн батлах тухай" А/04, А/16 дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох хосолмол аргачлал"-ын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнийг тодорхойлохоор "Босго оноо шинэчлэн тогтоох тухай" Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/135 дугаар тушаалаар батлууллаа. Ингэснээр БСШУЯ, ХЗЯ, ЭМЯ зэрэг байгууллагуудад нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэний мэдээллийг өгч, холбогдох үйлчилгээнд хамруулах юм.</p>	
--	--	--	--	--	--	--

6.	<p><b>Арга хэмжээ 1.6.</b>  <b>“Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусlamж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ын төслийг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, батлуулна.</b></p>	<p>Засгийн газрын тогтоол-1</p>	<p>30%</p>	<p>100%</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх хөнгөлөлт, тусlamжийн үйлчилгээний шат дамжлагыг багасгаж, хүндрэл, чирэгдэлгүй болгох, хэрэгжилтийн явцад тулгамдаж байгаа зарим асуудлыг сайжруулах зорилгоор Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөнгөлөлт, тусlamж үзүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын гишүүдээс санал авсан. Журмын төсөлд</p> <p>-Протез, ортопед үйлдвэрлэж байгаа байгууллагад зориулсан системийн хөгжүүлэлтийг (<a href="http://ehalamj.mn">ehalamj.mn</a>) нэгдсэн системд хийж, тухайн иргэний өмнө авсан нийгмийн халамжийн үйлчилгээний мэдээллийг харах эрхийг Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн харьяа протез, ортопедийн үйлдвэр, Эрхэм чанар протезийн үйлдвэр болон бусад үйлдвэрт нээх;</p> <p>-Үйлдвэрийн эмч хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд тохирсон протез, ортопедийн хэрэгсэл шаардлагатай талаар тодорхойлолтыг <a href="http://ehalamj.mn">ehalamj.mn</a> нэгдсэн системд үүсгэх;</p> <p>-Хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрийн сонгосон протез, ортопедийн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх байгууллага, эмийн сангаас протез,</p>	<p>01-06</p>

					<p>ортопед хийлгэх буюу тусгай хэрэгслийг худалдан авах;</p> <p>-Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөнгөлөлт, тусламж олголтын хэрэгжилтийн хяналт үнэлгээг сайжруулах, иргэний сэтгэл ханамжийн судалгааг авч байх, ажилтны ёс зүй, харилцааг сайжруулах, сургалт зохион байгуулах;</p> <p>-Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь тусламж, хөнгөлөлтэд хамрагдсан иргэнд олгосон протез, ортопед, тусгай хэрэгслийн чанар, үйлчилгээнд хөндлөнгийн болон олон нийтийн хяналт, шалгалтыг жилд нэгзээс доошгүй удаа зохион байгуулах болон өөр бусад зохицуулалтыг тусгасан.</p> <p>Журам боловсруулахтай холбоотой төр, териин бус, олон улсын байгууллага, албан хаагчидтай уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулан, санал авч журмын төсөлд тусган ажилласан.</p> <p>Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнийг шинэчлэн батлах тухай” 363 дугаар тогтооолын хавсралтаар баталсан “Нийгмийн халамжийн сангаас олгох протез,</p>	
--	--	--	--	--	---	--

				<p>ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ"-д нэмэлт оруулж 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын 248 дугаар тогтоолыг батлуулсан.</p> <p>Батлагдсан төсөвтэй уялдуулан байнгын асаргаа шаардлагатай, хүнд хэлбэрийн өдөр тутам живх хэрэглэдэг, 2-оос дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох живхний үнийг 3 жилд нэг удаа олгох 1,800,000 төгрөг олгохоор Засгийн газрын тогтоолоор батлуулав.</p> <p>Түүнчлэн иргэдээс сонсголын аппаратны чанар, эдэлгээ, нийлүүлэлтийн асуудлаар өргөдөл, гомдол нэлээд олон ирдэг. Үүнтэй холбогдуулан хяналт, шалгалт, аудитын байгууллагаас олон зөрчил илрүүлж, дүгнэлт, зөвлөмж өгдөг. Иргэдийн хэрэгцээг хангадаггүй, чанар, эдэлгээ муутай, шуугидаг, зай нь амархан мууддаг, хямд үнэтэй сонсголын аппарат нийлүүлдэг, таарч тохирохгүй сонсголын аппарат хэрэглэснээр гарч болзошгүй хүндрэл, бэрхшээл үүсдэг талаар иргэдээс гомдол ирдэг. Иймд Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын 248 дугаар тогтоолоор "сонсголын дижитал аппаратны чанарт тавигдах техникийн үзүүлэлт"-ийг нэмж тусган батлуулсан.</p>	
--	--	--	--	--	--

7.	<p><b>Арга хэмжээ 1.7.</b>          "Хүүхдийн мэнгэн тэтгэмж олгох журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, батлуулна.</p>	Засгийн газрын тогтоол-1		100%	<p>Оросын Холбооны Улсын Элчин сайдын яамнаас тус улсаас Монгол Улсад байнга оршин сууж байгаа иргэний хүүхдийн мэнгэн тэтгэмжид хамрагдахгүй байгаа талаар тус яам болон Монгол Улсын Их Хурлын дарга, Гадаад харилцааны сайдад хандан удаа дараа хүсэлт ирүүлсэн. Уг хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 236 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Хүүхдийн мэнгэн тэтгэмж олгох журам"-д өөрчлөлт оруулах төслийг боловсруулан, Гадаадын иргэн, харьяатын газраас тоон мэдээлэл авч, холбогдох яамдын саналыг тусгаж, Засгийн газрын 2025 оны 05 сарын 21-ний өдрийн "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 247 дугаар тогтоолыг батлуулсан.</p>	03-05
8.	<p><b>Арга хэмжээ 1.8.</b>          Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд насны хишигийн хэмжээг Засгийн газар батлах зохицуулалт орсонтой холбогдуулан Засгийн газрын 2012 оны "Тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох тухай" 136 дугаар тогтоолын төсөлд</p>	Засгийн газрын тогтоол-1	Ахмад настны тухай хууль	100 %	<p>Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2025 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Насны хишигийн хэмжээг батлах зорилгоор Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан 2025 оны 01/ тоот албан бичгээр яамдын саналыг авч тусгасан. Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ийн өдрийн "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" тогтоолыг батлуулан 2012 оны 136 дугаар тогтоолын хавсралтад Насны хишигийн хэмжээг тусгасан бөгөөд уг</p>	01-03

	өөрчлөлт оруулах төсөл боловсруулан Засгийн газрын тогтоолоор батлуулна.				тогтоолыг 2025 оноос дагаж мөрдөж байна.		
9.	<b>Арга хэмжээ 1.9.</b> “Ахмад настны үйлчилгээний жишиг үнэ, иргэний төлөх төлбөрийн хэмжээ батлах тухай” Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалын төслийг боловсруулан батлуулна.	Хамтарсан тушаал-1		100 %	<p>Ахмад настны тухай хуульд заасан ахмад настны идэвхтэй насхилтыг дэмжих болон асаргааны хувилбарт үйлчилгээний жишиг үнэ болон иргэний хариуцах төлбөрийн хэмжээг тогтоох тооцоо судалгаа хийж, Олон улсын байгууллагын зөвлөхүүдийн зөвлөмж, аргачлалд үндэслэн боловсруулсан.</p> <p>“Ахмад настны үйлчилгээний жишиг үнэ болон иргэний хариуцан төлөх төлбөрийн хэмжээ батлах тухай” 2 сайдын хамтарсан тушаалын төслийг хянан үзэж батлуулах тухай албан бичгийг Сангийн яаманд 2025.01.14-ний 01/97 тоот албан бичгээр хүргүүлэн 2025 оны А/51, А/37 тоот хамтарсан тушаалыг батлуулсан.</p> <p>Тушаалыг ахмад настны идэвхтэй насхилтыг дэмжих төвийн үйлчилгээ болон асаргааны хувилбарт (өдрөөр асрах, гэрээр асрах, түр, урт байнгын хугацаагаар асрах) үйлчилгээнд мөрдөж байна.</p>	01-03	
10.	<b>Арга хэмжээ 1.10.</b> Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт	Сайдын тушаал-1		100 %	Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ний өдөр Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан бөгөөд уг хуулийг дагаж Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон.	01-02	

	тавигдах шалгуур, журам боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлуулна.			Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дэргэдэх Магадлан итгэмжлэлийн зөвлөлөөс магадлан итгэмжилж, үйлчилгээ явуулах эрх олгодог байсан. Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт орж, уг хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэгт “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, журам, үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хийх гэрээний загвар, аргачлал, заавар, үнэ тарифыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны дагуу Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх аргачлал, заавар, үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, үйлчилгээ үзүүлэх журмыг хуульд орсон өөрчлөлтийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/35 дугаар тушаалаар баталсан. Энэ хүрээнд өмнө баталж мөрдүүлж байсан эрх зүйн баримт бичгүүд, түүний үйлчлэл зэргийг судалж шинээр боловсруулах журам, тавигдах шалгуурт нарийвчлан тусгаж, зохицуулалтын хувьд илүү ойлгомжтой, уян хатан, ил тод, нээлттэй байх, үйлчилгээг мэргэжлийн болгох,	
--	---	--	--	---	--

					мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах зэргийг анхааран эрх зүйн зохицуулалтыг хийв.		
11.	<b>Арга хэмжээ-1.11.</b> Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, журам батлуулж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянуулан захиргааны эрх зүйн хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлнэ.	100 %	0	100%	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх аргачлал, заавар, үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, үйлчилгээ үзүүлэх журмыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/35 дугаар тушаалаар шинэчлэн батлуулж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянаад захиргааны эрх зүйн хэм хэмжээний актын нэгдсэн сангийн 7156 дугаарт бүртгүүлэн ажилласан.	01-03	
12.	<b>Арга хэмжээ-1.12.</b> Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний аргачлал, заавар, шалгуур, журам, гэрээний загвар, үнэ тарифын журам боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлуулна.	Сайдын тушаал-1	0	100%	Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ний өдөр Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан бөгөөд уг хуулийг дагаж Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дэргэдэх Магадлан итгэмжлэлийн зөвлөлөөс магадлан итгэмжилж, үйлчилгээ явуулах эрх олгодог байсан. Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт орж, уг хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэгт “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний	01-03	

				<p>чанарт тавигдах шалгуур, журам, үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хийх гэрээний загвар, аргачлал, заавар, үнэтарифыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан.</p> <p>Иймд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/53 дугаар тушаалаар Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний аргачлал, заавар, үйлчилгээний үнэтариф, гэрээний загварыг баталсан.</p> <p>Энэ хүрээнд өмнө баталж мөрдүүлж байсан эрх зүйн баримт бичгүүд, түүний үйлчлэл зэргийг судалж шинээр боловсруулах журам, тавигдах шалгуурт нарийвчлан тусгаж, зохицуулалтын хувьд илүү ойлгомжтой, уян хатан, ил тод, нээлттэй байх, үйлчилгээг мэргэжлийн болгох, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах зэргийг анхааран эрх зүйн зохицуулалтыг хийв.</p>	
--	--	--	--	---	--

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/ д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь

	1	2	3	4	5	6	7
1.	<b>Арга хэмжээ 1.</b> Нийгмийн хамгааллын чиглэлээр олон улсын хуралд оролцож, бусад улсын туршлага судлах.	100%	0%	100%	<p>Монгол Улсад асаргааны хувилбарт үйлчилгээг нэвтрүүлэх, Ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах, Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилготой олон салбарын хамтарсан баг 2025 оны 2 сарын 12-ноос 19-ний өдрүүдэд Япон Улсын Засгийн газрын Жайка байгууллагын санхүүжилтээр сургалт, туршлага судлан ажиллав.</p> <p>Энэ хүрээнд Япон Улсын нийгмийн хамгааллын тогтолцоо, асаргааны даатгал, асаргааны олон төрлийн үйлчилгээ: гэрийн асаргаа, өдрийн үйлчилгээ, түр байршуулан асрах, урт хугацааны асаргаа, байнга асрах үйлчилгээ, эрүүл мэндийн болон асаргааны даатгалын санхүүжилт, тусламж үйлчилгээ, хүний нөөцийг бэлтгэх асрахуйн сургууль зэрэг тэр, хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагааг газар дээр нь судлан танилцаж, мөн сургалтад хамрагдлаа. Туршлагын талаар УИХ-ын асрах үйлчилгээний эрх зүйн орчинг сайжруулах Баясгалан гишүүнээр ахлуулсан ажлын хэсэгт</p>	01-06	

					мэдээлэл хийсэн. Мөн Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Монгол Улсад урт хугацааны асаргааны тогтолцоог бүрдүүлэх журам, дүрмийг боловсруулах, хэрэгжүүлэхэд туршлагаас суралцан тусгасан. Мөн салбарын ажилтнуудад Японы туршлагаар цахим сургалт хийсэн.		
2.	<p><b>Арга хэмжээ 2.</b>          Нийгмийн халамжийн чиглэлээр бусад улсын туршлагыг судалж, хууль журмын танилцуулга, холбогдох судалгаанд тусгах, шаардлагатай туршлагыг өөрийн орны нөхцөлд нийцүүлэн хууль, журамд тусгах</p>	100%	0%	100%	<p>Ядуурал болон Нийгмийн халамжийн чиглэлээр Дэлхийн банк, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс гаргасан тайланг судлав. Ядуурлын асуудлаар УИХ-ын Тогтвортой хөгжлийн зорилтын дэд хороонд мэдээлэл бэлтгэн хүргүүлэв. Нийгмийн халамжийн чиглэлээр Филиппин, Япон, Эстони, Казакстан зэрэг улсын туршлага дээр Солонгосын хуулиудыг нэмж судлав.</p>	01-06	

#### ТАЙЛАН ГАРГАСАН:

Хөдөлмөрийн бодлогын газрын  
 Нийгмийн халамжийн хэлтсийн дарга  
 Юрагийн Отгонбилэг  
 ( Албан тушаал )

Ю.Отгонбилэг / ..... / ..... / .....

( Нэр, гарын үсэг ) ( Огноо )

#### ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

Хөдөлмөрийн бодлогын газрын дарга

Х.Тамир / ..... / .....

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ХӨДӨЛМӨРИЙН  
БОДЛОГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ЮРАГИЙН  
ОТГОНБИЛЭГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,  
МЭРГЭШЛИЙН ТУВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС  
(УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАН)**

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Нэгжийн нэр: Хөдөлмөр бодлогын газрын Нийгмийн халамжийн хэлтэс

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал		Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо	
			1	2	3	4	5
	Оноо		60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл		

**Зорилт 1. "2.1.1. Хөдөлмөр эрхлээгүй иргэдийг ажлын байраар хангах, ядуурлыг  
бууруулах, тогтвортой ажлын байр бий болгохыг дэмжих арга хэмжээний хөтөлбөр,  
төсөл боловсруулж хэрэгжүүлэх"-ийн биелэлт**

1.	<b>Арга хэмжээ 1.1.</b> Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлнэ.	58	10	68	68	
2.	<b>Арга хэмжээ 1.2.</b> Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалтад нэмэлт оруулж, Засгийн газрын тогтоолоор батлуулна	60	10	70	70	
3.	<b>Арга хэмжээ 1.3.</b> Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулахад Эрүүл мэндийн яам, харьяа байгууллагатай хамтран ажиллах, чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулна.	60	10	70	70	
4	<b>Арга хэмжээ 1.4.</b> "Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, батлуулна.	55	16	55	65	
5	<b>Арга хэмжээ 1.5.</b> "Хүнсний эрхийн бичиг олгох журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тушаалын төслийг боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлуулна.	55	10	65	65	
6	<b>Арга хэмжээ 1.6.</b>					

	"Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам"-ын төслийг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, батлуулна.	55	10	65	65
7	<b>Арга хэмжээ 1.7.</b> "Хүүхдийн мэнгэн тэтгэмж олгох журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, батлуулна.	60	10	70	70
8	<b>Арга хэмжээ 1.8.</b> Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд насын хишигийн хэмжээг Засгийн газар батлах зохицуулалт орсонтой холбогдуулан Засгийн газрын 2012 оны "Тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох тухай" 136 дугаар тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах төсөл боловсруулан Засгийн газрын тогтоолоор батлуулна.	60	10	70	70
9	<b>Арга хэмжээ 1.9.</b> "Ахмад настны үйлчилгээний жишиг үнэ, иргэний төлөх төлбөрийн хэмжээ батлах тухай" Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалын төслийг боловсруулан батлуулна.	60	10	70	70
10	<b>Арга хэмжээ 1.10.</b> Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, журам боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлуулна.	60	10	70	70
11	<b>Арга хэмжээ-1.11.</b> Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, журам батлуулж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянуулан захиргааны эрх зүйн хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлнэ.	60	10	70	70
12	<b>Арга хэмжээ-1.12.</b> Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний аргачлал, заавар, шалгуур, журам, гэрээний загвар, үнэ тарифын журам боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлуулна.	60	10	70	70
<b>Дундаж оноо:</b>				<b>68,5</b>	

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
				1
1.	<b>Арга хэмжээ 1.</b> Нийгмийн хамгааллын чиглэлээр олон улсын хуралд оролцож, бусад улсын туршлага судлах	100	15	15
2.	<b>Арга хэмжээ 2.</b> Нийгмийн халамжийн чиглэлээр бусад улсын	100	15	15

	туршлагыг судалж, хууль журмын танилцуулга, холбогдох судалгаанд тусгах, шаардлагатай туршлагыг өөрийн орны нөхцөлд нийцүүлэн хууль, журамд тусгах		
	<b>Дундаж оноо</b>	<b>15.</b>	<b>15</b>

### 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
			1
1.	Хандлага, ёс зүй	7	7
2.	Дүн шинжилгээ хийх	7	7
3.	Асуудал шийдвэрлэх	7	7
4.	Хариуцлагатай байдал	7	7
5.	Ажлын цаг ашиглалт	7	7
<b>Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)</b>			7
6.	Мэргэжлийн ур чадвар 1.	7	7
7.	Мэргэжлийн ур чадвар 2.	7	7
8.	Мэргэжлийн ур чадвар 3.	7	7
	<b>Дундаж оноо</b>	<b>7</b>	<b>7</b>

### 4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)	
		1	2
1.	Хандлага, ёс зүй	8	8
2.	Багаар ажиллах	8	8
3.	Харилцаа	8	8
	<b>Дундаж оноо</b>	<b>8</b>	<b>8</b>

### 5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлтт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	68,5
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	75
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ )	7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтыг бичих)	
<b>Нийт оноо =</b> ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		<b>98,5</b>

**Үнэлгээ өгсөн:**

**Нэгжийн дарга**

Хөдөлмөр бодлогын

газрын дарга  
(албан тушаал)

Х.ТАМИР /Х.Тамир...../  
(гарын үсэг) (албан хаагчийн нэр)

2025.06.09 (огноо)

Үнэлгээтэй танилцаж,  
зөвшөөрсөн:

Нийгмийн халамжийн  
хэлтсийн дарга  
(албан тушаал)

Төрийн жинхэнэ албан хаагч:

(гарын үсэг)

Ю.ОТГОНБИЛЭГ  
/Ю.Отгонбилэг.../  
(албан хаагчийн нэр)

2025.06.13... (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

.....  
(албан тушаал)

.....  
(гарын үсэг)

/В.Д.Балжигмаргын  
(албан хаагчийн нэр)

2025.06.20... (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

.....  
(албан тушаал)

.....  
(гарын үсэг)

/Д.Балжигмаргын/  
(албан хаагчийн нэр)

2025.06.20... (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

(албан тушаал)

Л.МӨНХЗУЛ



/Л.Монхзүл.../  
(албан хаагчийн нэр)

2025.06.20.. (огноо)